



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/356

Хэрлэн сум

Аян зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хорин долоодугаар хуралдааны 8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Нэгдсэн эмнэлгийн тасаг, нэгжүүдийн дунд зохион байгуулсан Эерэг хандлага-Эмнэлгийн тусламж үйлчилгээ аяны зардалд 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ